



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 4/36

Булган сум

Булган, Орхон аймгийн хамтран ажиллах
гэрээг байгуулах ажлын хэсэг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган, Орхон аймгийн хамтран ажиллах гэрээг байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:	Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүдэд:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
	Байгаль орчны газрын дарга
	Татварын газрын дарга
	Бугат сумын Засаг дарга
	Бүрэгхангай сумын Засаг дарга
	Орхон сумын Засаг дарга
	Сэлэнгэ сумын Засаг дарга
	Хангал сумын Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Гадаад харилцааны мэргэжилтэн

2.Хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/08 дугаар захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР